**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 03 өдөр Дугаар А/535 Номгон

"Том ахын аялал" танин мэдэхүйн
нэвтрүүлэг хийлгэх тухай

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Сангийн сайдын 2021 оны оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын үндэсний олон нийтийн телевизийн Гэр бүл сувгийн "Том ахын аялал" танин мэдэхүйн нэвтрүүлэг хийх бэлтгэлийг Баянхонгор аймгийн байгаль, түүх, соёлын дурсгалт газар, аймаг, сум орон нутгийн төр захиргааны байгууллага, боловсрол, соёл, хүүхдийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах чиглэлээр хийгдэх нэвтрүүлгийн бэлтгэл ажлыг Галуут, Эрдэнэцогт, Баянхонгор сумын нутаг дэвсгэрт 2021 оны 09 дүгээр сарын 06-11-ний өдрүүдэд зохион байгуулсугай .

2.Энэхүү арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангаж хамтран ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Наранбаяр/, Галуут, Эрдэнэцогт сумын Засаг дарга А.Батбаяр, Д.Цэвэгдорж нарт үүрэг болгосугай.

3.Уг арга хэмжээнд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталж, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1,986,000 / Нэг сая ёсон зуун наян зургаан мянган/ төгрөгийг ажлын гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.

601210287

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Г.Энхбаярт даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/555 дугаар захирамжийн хавсралт

# МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗИЙН "ТОМ АХЫН АЯЛАЛ" ТАНИН МЭДЭХҮЙН НЭВТРҮҮЛЭГ ХИЙХ ЗАРДАЛ

| № | Зардлын нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | ДТ түлш, А-80 | Литр | 300 | 2500 | 750000 |
| 2 | А-80 шатахуун | Литр | 120 | 2000 | 240000 |
| 2 | Буудлын хөлс | Хоног/хүн | 2/6хүн | 25000 | 300000 |
| 3 | Төвөөс ажиллах хүнийн хоолны зардал/ | Хүн /хоног | 6 хүн 5 хоног | 12000 | 360000 |
| 4 | Орон нутгаас ажиллах хүний хоолны зардал | Хүн/хоног | 7 хүн 4 хоног | 12000 | 336000 |
| Бүгд | | Нэг сая ёсон зуун наян зургаан мянган төгрөг | | | 1986000 |

_______oOo_______